



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

16100 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо,
Утас/Факс: (976) 7000 7636, И-мэйл: info@rtdc.gov.mn,
Вэбсайт: rtdc.gov.mn

2020.03.05 № 1110
танай _____-ны № _____-т

..... КОМПАНИД

Тус төв Улаанбаатар-Хөшигийн хөндийн чиглэлийн тууш замын Хан-Уул дүүргийн Жаргалантын амын уулзвар орчимд алба хаагчид 24 цагаар үүрэг гүйцэтгэх боломжтой зөөврийн дулаалгатай сууц бариулах хүсэлтэй байгаа тул эрх бүхий этгээдүүдээс үнийн санал битүүмжлэн ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 15⁰⁰ цагаас өмнө Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ийн байр 202 тоот өрөө хаягаар ирүүлнэ үү.

Үнийн саналтай холбоотой мэдээ, мэдээллийг 99238615 тоот утсаар холбогдон авч болно. Нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний техникийн шаардлагыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: хуудас

ЗАХИРАЛ



Р.БУД

**БАТЛАВ.
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ЗАХИРАЛ Р.БУД**



Огноо: 2020-03-05

**ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН УЛААНБААТАР-ХӨШИГИЙН ХӨНДИЙН
ЧИГЛЭЛИЙН ТУУШ ЗАМЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЖАРГАЛАНТЫН АМЫН
УУЛЗВАР ОРЧИМД ЗӨӨВРИЙН ДУЛААЛГАТАЙ СУУЦ ХУДАЛДАН АВАХ**

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ
ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: Зөөврийн дулаалгатай сууц худалдан авах
Тендерийн дугаар: ЗТХТ/2020030501

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Зам тээврийн хөгжлийн төв нь сонгогдсон эрх бүхий шалгаруулалтанд оролцогчдоос Улаанбаатар-Хөшигийн хөндийн чиглэлийн тууш замд зөөврийн дулаалгатай сууц барих, суурилуулах үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэхдээ ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан байна.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 15:00 цагаас өмнө БГД-н 20-р хороо Зам тээврийн хөгжлийн төв байранд ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11:00 цагт нээнэ.

Хоёр. ҮНИЙН САНАЛ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий оролцогч**
 - 1.1. Оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу төслийн шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Үнийн санал ирүүлэх, нээлт**
 - 2.1. Захиалагч ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Үнийн саналыг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Иж бүрдэл**
 - 3.1. Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх шалгаруулалт нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
- 4. Шалгаруулалтын үнэ**
 - 4.1. Үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба шалгаруулалтанд оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Оролцогч үнийн хөнгөлөлтийг тусган санал болгож болно.
 - 4.3. Оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Оролцогч нь материал хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн үнийн саналын арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан саналын дүнг оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв шалгаруулалтанд оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний шалгууралтаас татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон үнэ байна.

Гурав. ҮНИЙН САНАЛ ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none">- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар- Сүүлийн 1-2 жилийн туршлагын мэдээлэл
ТӨӨЗ 2.1	Үнийн санал хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 15:00 цагт Байгууллагын хаяг: БГД-н 20-р хороо Зам тээврийн хөгжлийн төвийн байр 202 тоот өрөөнд
ТӨӨЗ 2.1	Нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: БГД-н 20-р хороо Зам тээврийн хөгжлийн төвийн байр Огноо: 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж

Улаанбаатар-Хөшигийн хөндийн чиглэлийн тууш замын Хан-Уул дүүргийн Жаргалантын амын уулзвар орчимд алба хаагчид 24 цагаар үүрэг гүйцэтгэх боломжтой зөөврийн дулаалгатай сууц барих, суурилуулах
Үүнд:

Зөөврийн дулаалгатай сууц

Байгууламжийн нэр		Бүтээгдэхүүний төрөл	Тоо хэмжээ
4*5 м сандвичэн сууц		Оффис	1 ш
Цахилгаан	Гэрэл	Цахилгаан хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй.	1 ш
	Гадна гэрэлтүүлэг	Цахилгаан хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй.	1 ш
	Разетка	Энгийн	2 ш
	Унтраалга	Энгийн	1 ш
	Автомат	Энгийн	1 ш
	Автоматын хайрцаг	Энгийн	1 ш
	Гадна разетка	Энгийн	1 ш
Шал		Паркет	20 м2
Хаалга		Бүргэд	1 ш
Цонх		Вакум цонх 100*120	3 ш
Хана	Дотор тал	Өнгөт хавтан	
	Гадна тал	Дулаалгын сайдинг	
Тааз		Өнгөт хавтан	
Халаалт		Цахилгаан халаалт	

Техникийн тодорхойлолт:

- Цахилгааны утас: Аюулгүй байдал хангасан, цахилгааны хэрэглээг даах чадалтай, цахилгааны монтаж нь ил хийгдэнэ.
- Цонх: Урагшаа, баруун, зүүн тийш харсан 3 цонхтой байна.
- Шал: Паркетан шал, 4 см хөөсөнцөр дулаалгатай.
- Тааз: Өнгөт хавтан, 8 см хөөсөнцөр дулаалгатай
- Дээвэр: Шувуу нуруу эсвэл усны хаялага шийдсэн.
- Гадна өнгө: Сонголтоор
- Агааржуулалтын систем шийдсэн байна.

Баталгаат хугацаа 1 жилээс доошгүй

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно.

Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулах шаардлагагүй.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Зөөврийн сууцын олон талаас авсан бодит зургийг схем зургийн хамт хавсарган ирүүлэх